



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 8/180

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/17 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Эрүүл мэндийн төвд Биохимийн автомат анализатор нийлүүлэх" төсөл арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга:	Б.Цогжавхлан	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
Гишүүд:	Л.Бадрах	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын инженер
	Ө.Амарзаяа	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
Нарийн бичиг:	С.Өлзийсайхан	1 дүгээр хорооны иргэн
	Д.Амгалан	Худалдан авах ажиллагааны албаны дотоод ажил, тайлан мэдээ хариуцсан ахлах мэргэжилтэн

2.Хууль, тогтоомжийн дагуу ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо (Б.Цогжавхлан)-нд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД